



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



БАТЛАВ.
БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Г.НЯМДУЛАМ



БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН НЭРЭМЖИТ
“ӨРӨГ УГСРАГЧ” МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН УР ЧАДВАРЫН
УЛСЫН **ХОЁРДУГААР** УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зохион байгуулагч: Барилгын политехник коллеж

Барилгын мэргэжлийн зөвлөл

Хамтран оролцогч: Боловсролын ерөнхий газар

Улаанбаатар хот
2024 он

**БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН НЭРЭМЖИТ
ӨРӨГ УГСРАГЧ МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН УР ЧАДВАР-2024 УЛСЫН
II УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Нэг. Уралдааны зорилго

Барилгын салбарын нэр хүндийг өсгөх, өрөг угсрагч мэргэжлийг сурталчлах, мэргэжлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, урамшуулах, багшийн ур чадварын түвшнийг олон улсын жишигтэй харьцуулах замаар ур чадварыг үнэлэх, харилцан туршлага солилцох болон чадамжийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд оршино.

Хоёр. Уралдаан зохион байгуулагдах газар, хугацаа

Өрөг угсрагч мэргэжлийн багш нарын дунд зохион байгуулагдах улсын II уралдаан 2024 оны 12 дүгээр сарын 09-10-ны өдөр Барилгын политехник коллежийн өрөг угсрагч мэргэжлийн дадлагын газарт зохион байгуулагдана.

Гурав.Хамрах хүрээ

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын барилгын (өрөг угсрагч) мэргэжлийн багш нар оролцоно.

Дөрөв.Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Шалгуурыг хангасан, эрх бүхий үнэлгээний ажилтан, шүүгч, хөндлөнгийн баталгаажуулагч байна.

Тав. Уралдааны зохион байгуулалт

- ✚ Оролцогчид нь 2024 оны 12 сарын 05 хүртэл Bayartsetseg@cc.edu.mn мэйл хаягаар оролцох эсэхийг урьдчилан мэдэгдэж бүртгүүлнэ.
- ✚ Уралдаан 2024 оны 12 сарын 10-ны өдөр явагдана.
- ✚ Уралдаанд оролцогч бүр оролцооны төлбөр **400000** төгрөгийг **100900015142** тоот дансанд шилжүүлнэ. /Жич мэдэгдэнэ/
- ✚ Оролцогч нь нийгмийн даатгал төлсөн тодорхойлолтын лавлагаа /e-mongolia/ авчирна.
- ✚ Техникийн зөвлөгөөн 2024 оны 12 дүгээр сарын 09-ны 10:00 цагт 206 тоотод болно.
- ✚ Ажлын даалгаврын 30 хувийн өөрчлөлтийг техникийн зөвлөгөөний хурал дээр танилцуулна.
- ✚ Уралдааныг дэлхийн ур чадварын тэмцээний стандарт болон үнэлгээний системийн дагуу зохион байгуулна.
- ✚ Оролцогчид нь уралдааны удирдамж, техникийн баримт бичгийг мөрдөж ажиллана.
- ✚ Оролцогчид уралдааны үеэр гар утас, таблет ашиглахгүй.
- ✚ Удирдамжид тусгагдсан багаж хэрэгслийг оролцогчид авчирна.
- ✚ Оролцогчид ХАБЭА-н шаардлага болон аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажиллана.
- ✚ Бусад дэмжигчид уралдааныг тодорхой зайнаас ажиглаж сонирхож болно.

Зургаа.Тэмцээнд хэрэглэгдэх гар багаж, хэмжих багаж хэрэгсэл тоног төхөөрөмж

А.Оролцогчид бэлтгэн авч ирэх шаардлагатай гар багаж, хэмжин шалгах багаж хэрэгслийн жагсаалт. Үүнд:

№	Багаж хэрэгсэл	Тоо хэмжээ	
1	Өргийн нийвий	ш	1
2	Тэгш ус ком-Рейк	ш	1
3	Метр	ш	1
4	Өнцөг хэмжигч 90 ⁰	ш	1
5	Ан заадас засагч -ком	ш	1
6	Өргийн алх	ш	1
7	Чиг утас	ш	1
8	Ажлын зураг гаргах цаас -багц	боод	1
9	Цаасны хутга	ш	1
10	Шугам /1м хүртэлх урттай/	ш	1
11	Гортиг	ш	1
12	Балын харандаа, баллуур ком	ш	1
13	Тооны машин	ш	1

Б. Материал болон зуурмаг, тоног төхөөрөмж

Даалгаварт ашиглагдах тоосго зүсэгч машин, бүтэн тоосго, зуурмагт орох материал, зуурмагийг уралдаан зохион байгуулагч тал урьдчилан бэлдсэн байна.

Долоо. Оролцогчийн гүйцэтгэлд үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг техникийн зөвлөгөөн болох өдөр танилцуулна. Уралдааны даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхдээ шүүгч бүр үнэлгээний шалгуур үзүүлэлтэд заасны дагуу эцсийн бүтээгдэхүүнийг оролцогч нарын хэрэглэсэн багаж хэрэгслээр хэмжилт хийж үнэлгээ өгч оноожуулна. Онооны байдлаар цуваагаар байр эзлүүлнэ.

Найм. Шагнал урамшуулал

- 1-р байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал
 - 2-р байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал
 - 3-р байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Оролцогчдод батламж олгоно.

Санамж: Тэмцээнд оролцогч нь хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж, хувийн бэлтгэлээ хангасан байна.Үүнд:


- Ажлын хувцас
- Хөдөлмөр хамгааллын нүдний шил
- Чихэвч эсвэл чихний бөглөө
- Ажлын гутал
- Хошуувч /зүлгэлтийн үед ашиглах/
- Анхны тусламжийн хувийн хэрэгсэл / Жишээ нь: эмчийн хяналт дор байнга уудаг эм, хурууны лент гэх мэт/

- Оролцогч нь тэмцээнд ашиглагдах хэмжих, шалгах багаж, тоног төхөөрөмжийг өөрөө бэлдэж, бүрэн ажиллагаатай эсэхийг урьдчилан шалгаж бэлтгэл ажлыг хангасан байх.

Ес. Ажлын даалгавар

Ажлын даалгаврыг /Зураг 1/ 5 цаг буюу 300 минутын хугацаанд гүйцэтгэнэ. Даалгаварт 30%-ийн өөрчлөлт оруулж техникийн зөвлөгөөний хурал дээр танилцуулна.

Жич: Бэлтгэлийн хугацаанд ан заадасны хэмжээ, дүүргэлтэнд анхаарах.



БАРИЛГЫН ӨРӨГ УГСРАГЧ МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН УР ЧАДВАРЫН
УЛСЫН УРАЛДААНД ОРОЛЦОХ ОРОЛЦОГЧИЙН БҮРТГЭЛ

№	Байгууллага	Багшийн овог	Багшийн нэр	Регистрийн дугаар	Холбоо барих утасны дугаар	Майл хаяг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						

Бүртгэл. Сургалтын арга зүйч. Д.Баярцэцэг 80050311

Барилгын өрөг угсрагч мэргэжлийн багш. Ц.Намжилмаа 91095799